



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Г Хорооны 2008 оны 77 дугаар тогтоолд 7  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн “Арилжааг зогсоосон компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 77 дугаар тогтоолын 4.1 дэх хэсэгт дор дурьдсан агуулгатай “г”, “д”, “е” заалтыг тус тус нэмсүгэй:

1/ 4.1 дэх хэсгийн “г”, “д”, “е” заалтууд:

“г” Үйл ажиллагаагаа сэргээхийн тулд шинэ хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах замаар санхүүжилт татах бол тэдгээртэй байгуулсан гэрээ, санхүүжилт нь хууль ёсны орлогоос бүрдсэнийг нотолсон баримтыг Хороонд ирүүлнэ.

“д” Шинэ хөрөнгө оруулагч нь цаашид компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшихээр гэрээнд тусгасан бол тэдгээр нь Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйл болон Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-д заасны дагуу хяналтын багцыг худалдан авах саналаа зарлах хүсэлтийг арилжаа сэргээх хүсэлтийн хамт ирүүлсэн байна.

“е” Компанийг өөрийн хөрөнгөөр болон хувьцаа эзэмшигчидийн хөрөнгөөр санхүүжүүлэх бол санхүүгийн эх үүсвэрийг нотолсон баримт, санхүүгийн тайлан, аудиторын дүгнэлт, үнэлгээчний тайлан, үл хөдлөх хөрөнгө болон өмчлөх эрхийн гэрчилгээ;

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн “Арилжааг зогсоосон компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 77 дугаар тогтоолын 4.1 дэх хэсгийн “а” заалтын “...төсөл...” гэсний дараа “...уг төсөлд цаашид эрхлэн

явуулахаар төлөвлөж буй бизнес төлөвлөгөө, түүний төсөв, үр ашгийн тооцоо;” гэж нэмсүгэй.

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн “Арилжааг зогсоосон компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 77 дугаар тогтоолын 4.2 дэх хэсгийн “а” заалтын “Хорооны 2006 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Нийтэд санал болгон

гаргасан үнэт цаасыг бүртгэх тухай журам” гэснийг “Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах тухай журам” гэж өөрчилсүгэй.

4. Тогтоолд нэмэлт, өөрчлөлтийг оруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН